

МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, үүрэг гүйцэтгэгч томилох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8, 76.1.9 болон Компанийн дүрмийн 18.13.7, 8.13.8, 12.7-р заалт, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны 2024 оны 04 сарын 08-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэр болон 2024 оны 04 сарын 12-ны өдрийн “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирал Жадамбаасүрэн овогтой Батчимэг нь ажлаас чөлөөлөгдөх өөрийн хүсэлтээ өгсөн тул 2024 оны 04 сарын 12-ны өдрөөс эхлэн “Мандал Даатгал” ХК-ны гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэхүү шийдвэртэй холбогдуулан “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Балдан овогтой Энхтүвшинийг томилсугай.

3. “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлж, шинэ үүрэг гүйцэтгэгч томилсонтой холбогдуулан ажил хүлээлцэх комисс байгуулж, тус комиссын гишүүнээр ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх Цалин урамшууллын хорооны дарга, Дэд захирал, Захиргаа хүний нөөц хариуцсан захирлыг томилсугай.

4. Хөдөлмөрийн тухай хууль болон тус Компанийн дүрэмд нийцүүлэн “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон Б.Энхтүвшинтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгосугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хууль болон журамд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос тохиромжтой этгээдийн талаар дүгнэлт гаргуулах, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч томилогдсон талаар хамтран ажилладаг байгууллагуудад албан бичиг хүргүүлж, нийтэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулахыг “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон Б.Энхтүвшинд даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2024 оны 04 сарын 12-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн компанийн тухай хуулийн 80.2-р заалтыг үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ